

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2020 оны 01 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

Онцгой байдлын байгууллагын 2019 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг танилцуулж байна.

Тус төлөвлөгөөнд 3 зорилт, 4 чиглэлийн хүрээнд 22 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан 22 ажил арга хэмжээ нь “**үр дүнтэй**”-зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрч сайн, үр дүн гарсан буюу **100** хувийн хэрэгжсэн байна гэж дүгнэлээ.

Мөн 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилт 100 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2019 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжсэн байдал	Үнэлгээ /хувиар/
Нэг. “ШУДАРГА, ХАРИУЦЛАГАТАЙ, ИЛ ТОД БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ” хүрээнд:				
1.	Авлигын эрсдэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх	1.1.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг төлөвшүүлэх.	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол журам” батлагдсантай холбогдуулан Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын нийт 7 сул орон тоонд тусгай шалгалт зохион хүсэлтийг Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөл 2019 оны 1/576, 1/617 дугаар албан бичгээр тус тус Төрийн албаны зөвлөлд санал хүргүүлэн ажиллаж алба хаагчийн шатлан дэвших нөхцлийг бүрдүүлэн ажилласан.	100
		1.1.2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулж буй Авлигын эсрэг 1 өдрийн багц сургалтад алба хаагчдыг хамруулах.	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй 2019.01.14-ний өдрийн “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтад Онцгой байдлын байгууллагаас 3 алба хаагч, авлигын эсрэг сургалтад нийслэлийн хүрээний Онцгой байдлын байгууллагуудын алба хаагчдыг 2019.03.01-ний өдрөөс эхлэн хуваарийн дагуу хамруулж 12 алба хаагч тус тус хамруулсан.	100
		1.1.3. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын шинээр томилогдсон ХАСХОМ хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох хууль, эрх зүйн акт болон ХАСХОМ гаргах зааврын тухай сургалт зохион байгуулах.	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/434 дүгээр тушаалын хүрээнд Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон ХАСХОМ хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудын сургалтыг 2019 оны 01 дүгээр 07-08-ны өдрүүдэд Онцгой байдлын ерөнхий газрын Соёлын төвд холбогдох хууль, эрх зүйн акт болон ХАСХОМ гаргах тухай сэдвүүдээр зохион байгуулсан. Сургалтад 26 алба хаагч хамрагдсан.	100
		1.1.4. Онцгой байдлын байгууллагаас зохион байгуулах сургалтуудад Авлигатай тэмцэх газар болон хууль, хяналтын	Онцгой байдлын байгууллагын 2019 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан нийт 37 дотоод сургалтуудад Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтнуудаар авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой	100

	байгууллагын холбогдох албан тушаалтнаар Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх хууль тогтоомжийн тухай сургалт, яриа таниулга хийлгэх.	хичээл, сургалтыг хөтөлбөрт нь тусган оруулж, арга хэмжээг зохион байгуулсан.	
	1.1.5. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, үүрэг, оролцоо, идэвх санаачилгыг дэмжих, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, түүнд хяналт тавих.	АТГ-аас зохион байгуулсан Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээг 2019.11.04-08-ны өдрүүдэд “ММСГ” судалгааны байгууллагын 3 ажилтан Онцгой байдлын ерөнхий газрын 30 алба хаагч, болон гаднаас үйлчлүүлэхээр ирсэн иргэд, мөн хамтын ажиллагаатай ТББ-уудын төлөөллийг хамруулсан.	100
	1.1.6. Зөрчил, дутагдал гаргасан албан тушаалтанд сонсох ажиллагаа явуулах, энэ талаар өөрт нь мэдэгдэж, тайлбар гаргах боломжийг хуульд заасны дагуу олгох.	Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд зөрчил, дутагдал гаргасан алба хаагчид сонсох ажиллагаа явуулах, өөрт нь мэдэгдэж, тайлбар гаргуулах арга хэмжээг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018.03.05-ны өдрийн А/86 дугаар тушаалаар батлагдсан “Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.	100
	1.1.7. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг танилцуулах, дахин зөрчил, дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.	Монгол Улсын Засгийн газраас 2017 онд “Сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах тухай” 01 дүгээр албан даалгавар, 2018 онд “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, Төрийн албаны тухай хуулийн шнэчлэлтэй холбогдуулан Онцгой байдлын байгууллагын “Сахилгын зөвлөгөөн”-ийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/91 дүгээр тушаалаар 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулж, Онцгой байдлын ерөнхий газрын удирдлага, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академиас холбогдох албан тушаалтнуудаар сургалт зохион байгуулж төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын офицер, ахлагч бүрэлдэхүүнээс нийт 108 алба хаагч хамруулан зохион байгуулав.	100
	1.1.8. Алба хаагчдын зүгээс хуулиар зөвшөөрөгдсөн давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгох, энэ талаарх мэдээллийг өгөх, хяналт тавих.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зөвшөөрөгдсөн давхар ажил эрхлэх, зөвшөөрөл олгосон мэдээлэл бүртгэгдээгүй болно.	100

		1.1.9. Алба хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг нэгтгэн, хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.	Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын 2018 оны ХАСХОМ-ийн тайланг нэгтгэн Авлигатай тэмцэх газарт Онцгой байдлын ерөнхий газрын 2019.02.26-ны өдрийн 2/368 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	100
Хоёр. “ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ” хүрээнд:				
2.	Байгууллагын нээлттэй байдал, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдлэх	2.2.1. Гамшгаас хамгаалах тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг олон нийтэд танилцуулах, алба хаагчдад сурталчилах, мэдээлэх өдөрлөг зохион байгуулах.	Гамшгаас хамгаалах тухай хууль болон шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, бодлогын баримт бичгийг алба хаагчид болон олон нийтэд сурталчлах хүрээнд байгууллагын neta.gov.mn цахим хуудсанд “Хууль, эрх зүй” гэсэн буланг нээж, 2015-2018 онд батлуулсан дүрэм, журам, зааврыг байршуулсан. Мөн албаны 14 хоног тутмын “Онцгой мэдээ” сонинд “Хуулийн булан” нээж шинээр гарсан хууль, дүрэм, журам, зааврыг цувралаар нийтлэн алба хаагчдад хүргэн ажиллаж байна. Салбар нэгжүүдэд тушаал, шийдвэр гаргахад нэн шаардлагатай хууль, тогтоомжийг нэгтгэн “Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл” нэртэйгээр Олон нийттэй харилцах төвийн хэвлэх хэсэгт 100 ширхэгийг хэвлүүлэн, салбар нэгжүүдэд олгох хуваарийг Онцгой байдлын ерөнхий газрын даргаар 2019.10.04-ний өдөр батлуулж, олгосон.	100
		2.2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжээс хийх шалгалтын төлөвлөгөө болон шалгалтын үр дүнг цахим хуудсаар мэдээлэх.	Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019.01.28-ны өдөр баталсан “Онцгой байдлын ерөнхий газраас 2019 онд зохион байгуулах хяналт шалгалтын нэгдсэн хуваарь”-ийг Онцгой байдлын ерөнхий газрын neta.gov.mn цахим сайтад байршуулсан. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд иж бүрэн шалгалт-4, /Нийслэлийн Онцгой байдлын газар, Баянгол дүүргийн ОБХ, Багануур дүүргийн ОБХ/, албаны шалгалт-27 /Завхан, Говьсүмбэр гэх мэт/, биелэлтийн шалгалт-3 /Дундговь, Төв, Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газар,/ тус тус зохион байгуулсан.	100
		2.2.3. Авлигын эсрэг мэдээлэл хүлээн авах зориулалт бүхий үүрэн телефоны тусгай дугаартай болох, мэдээллийг бүртгэлжүүлэн холбогдох арга хэмжээг авч хэвшүүлэх.	ОБЕГ-ын даргын 2019.04.30-ны өдрийн А/130 дугаар тушаалаар ОББ-ын хэмжээнд авлига, ашиг сонирхолын зөрчлийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах зорилгоор мэдээлэл хүлээн авах зааврыг батлуулж 2019.08.01-нээс албан ёсоор ажиллуулж эхэлсэн. 7777-8998 тусгай дугаарын утсанд холбогдон гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авч, бүртгэлжүүлэн цаг тухайд нь	100

			хянан шийдвэрлэхээр ажиллаж байгаа бөгөөд 2019 онд ОБЕГ-т мэдээлэл бүртгэгдээгүй болно.	
		2.2.4. Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бичгээр болон цахим сүлжээгээр санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах боломжийг бүрдүүлж, шуурхай шийдвэрлэж ажиллах.	2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар “Иргэд, олон нийттэй харилцах төв”-өөр дамжуулан Онцгой байдлын байгууллагад санал хүсэлт 17, гомдол 6, талархал 1, нийт 24 өргөдөл, гомдол ирснээс бүгдийг нь шийдвэрлэсэн байна. Онцгой байдлын ерөнхий газарт 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар бичгээр нийт 184 өргөдөл, хүсэлт ирснээс холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн 172, судлагдаж байгаа буюу хяналтын шатандаа байгаа 12 байна.	100
		2.2.5. Онцгой байдлын байгууллагын сул орон тооны зар, сонгон шалгаруулалт явуулах талаарх мэдээллийг цахим хуудсанд байршуулах, удирдлагын ил тод байдлыг хангах.	ОБЕГ-ын даргын 2019 оны А/229, А/230, А/231, А/232, А/233, А/234, А/235, А/236, А/237, А/238, А/239, А/240, А/241, А/242, А/243 дугаар тушаалуудаар албан тушаалын тодорхойлолтыг тус тус батлуулсан тул 10 дугаар сарын 01-ний 1/2236 албан тоот бичгээр хүсэлтээ гарган Төрийн албаны зөвлөлийн болон Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудсанд байршуулан, тусгай шалгалтыг зохион байгуулсан байна.	100
Гурав. “ТӨСӨВ, САНХҮҮ, АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ” хүрээнд:				
3.	Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх	3.3.1. 2018 оны төсвийн гүйцэтгэл, жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2019 оны төсөв, 2020 оны төсвийн төсөл, 2019 оны төсөвт орсон өөрчлөлт /ороогүй бол мэдээллэх/, төсвийн орлого бүрдүүлэлтийн мэдээлэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт зэргийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулах.	Онцгой байдлын байгууллагын 2019 оны батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан. Онцгой байдлын байгууллагын 2019 оны эхний хагас жил, жилийн эцсийн нэгжийн болон нэгдсэн тайланг УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын гаргасан 2006 оны 246, 388 дугаар тушаалуудаар батлагдсан журмын дагуу гаргаж МУ-ын Шадар сайдын ажлын албаар дамжуулан Сангийн яаманд нэгтгүүлэн ажилласан. Үндэсний Аудитын газраас 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсарын аудит, Санхүүгийн тайлангийн аудит, 2019 оны хөрөнгө оруулалт, худалдан авах үйл ажиллагаа, 2019 оны “Шилэн данс”-ны төлөвлөгөөт шалгалтыг тус тус хийж “Зөрчилгүй” дүгнэлттэй шалгагдсан. Онцгой байдлын байгууллагын 2020 оны төсөв урсгал зардал 104.6 тэрбум, хөрөнгийн болон стратегийн нөөц бүрдүүлэх зардал 12.0 тэрбум, нийт зарлагын дүн 116.7 тэрбум төгрөг байхаар батлагдсан.	100
		3.3.2. 2018 оны төсвийн зарлагын хэмнэлт, хэтрэлт, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын	Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын Хавсралт 8 (Хуулийн	100

		мөнгөн гүйлгээг холбогдох хуулийн хүрээнд цахим хуудсанд байршуулах.	6.4.4 заалтын хүрээнд 2019 онд хийгдсэн орлого, зарлагын мэдээллийг шилэн дансанд байршуулсан.	
		3.3.3. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт гаргаж цахим хуудсанд байршуулах.	Онцгой байдлын албанаас 2018 онд цэргийн тэтгэвэрт гарч тэтгэвэр тогтоолгосон болон нэг удаагийн тэтгэмж авах алба хаагчдын жагсаалт /135 алба хаагч/-ыг Онцгой байдлын ерөнхий газрын даргаар 2019.01.22-ны өдөр батлуулан, байгууллагын www.nema.gov.mn сайтад байршуулсан бөгөөд тэтгэмжийг жагсаалтын дагуу олгож байна.	100
		3.3.4. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байлгах, иргэдийн хэрэгцээ хангахуйц мэдээллийг байгууллагын самбарт байрлуулах.	Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй “Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг сайжруулах төсөл”, БНПУ-тай байгуулсан Засгийн газрын нөхцөлт зээлийн хүрээнд 9 нэр төрлийн 768 ширхэг тоног төхөөрөмж, 15 нэр төрлийн галын үндсэн албаны болон удирдлагын автомашиныг хүлээн авч Төв орон нутгийн Онцгой байдлын газар, анги байгууллагуудад хуваарилсан ба тухай бүр nema.gov.mn цахим хуудсанд хэрэгжилтийн талаарх мэдээллийг ил тод мэдээлж байна.	100
		3.3.5. Олон улсын болон дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хуваарилах ажлыг олон нийтэд ил тод байлгаж хэвлэл мэдээлэл, цахим хуудсаар мэдээлэх.	Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны А/35, А/123, А/157 дугаар тушаалуудаар төсвийн урсгал зардал, ард иргэдийн хандив тусламжаар худалдан авсан, Азийн хөгжлийн банкнаас хандивласан нийт 777,2 сая төгрөгийн үнэ бүхий 12 нэр төрлийн 1500 гаруй тоног төхөөрөмжийг Төв, орон нутгийн Онцгой байдлын анги байгууллагад хуваарилсан ба тухай бүр nema.gov.mn цахим хуудсаар мэдээлж байна.	100
		3.3.6. Шилэн дансны бүртгэл, мэдээллийг хуулийн хугацаанд тайлагнах, түүнд хяналт тавих.	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хүрээнд тухай бүр мэдээллийг оруулж, салбар нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.	100
4.	Худалдан авах ажиллагааны үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж,	3.4.1. Худалдан авах ажиллагааны 2019 оны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлэх, тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах, тендер	2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж Шадар сайдаар батлуулан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль”-д нийцүүлэн тендерийн зарыг tender.gov.mn цахим хуудас, “зууны мэдээ” өдөр тутмын сонинд зарласан. Онцгой байдлын албанд хувцас хэрэгсэл худалдан авах тендерийн бүх багцад гэрээ байгуулсан ба хэмнэлтийн 147,8 сая төгрөгөөр нэмэлт	100

хяналт, хариуцлагыг дээшлүүлэх	шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, 2019 оны худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт зэргийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулах.	гэрээг байгуулан 9 нэр төрлийн 3765 ш хувцас хэрэглэл хүлээн авсан. Засгийн газрын 2019 оны 257 дугаар тогтоолоор батлагдсан 746 сая төгрөгөөр 4 нэр төрлийн 404 иж бүрдэл тусгай зориулалтын хувцас хэрэглэл худалдан авсан. Тендерийн үр дүнг тухай бүр tender.gov.mn цахим хуудсаар нээлттэй мэдээлж байна.	
	3.4.2. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж, хяналт, хариуцлагыг сайжруулах.	Онцгой байдлын ерөнхий газраас 2019 онд зохион байгуулсан нийт нээлттэй болон харьцуулалтын тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд Монголын хуульчдын холбоо, Монголын барилгачдын холбоо, Гал унтраах техникийн олон төрөлт спортын холбоод зэрэг төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөллийг оролцуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу зохион байгуулсан.	100
Нийт төлөвлөсөн арга хэмжээ	22 арга хэмжээ	Төлөвлөгөөний хэрэгжилт /хувиар/	100%

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР